



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/194

Бор-Өндөр сум

**Засаг даргын мөрийн хөтөлбөрийн
зардлаас хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэхь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20 дахь хэсэг, Бор-Өндөр сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 2.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хийгдэх "Соёлын үйл ажиллагаанд зориулсан сандал худалдан авах" ажиллагааны санхүүжилт болох 74 844 000 (Далан дөрвөн сая найман зуун дөчин дөрвөн мянга) төгрөгийг Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас зарцуулсугай.

2.Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас зохих хууль дүрэм, журмын дагуу зарцуулахыг санхүүгийн албаны дарга (Э.Түвшинсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ